



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар 4936

Мандалговь

Архи, согтууруулах ундаа худалдах
түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай
зөвшөөрлийн эрх олгох,
сунгах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4, 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайнцагаан сумын “Сүүж өртөө мандал” ХХК-ний зоогийн газарт архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, Дэлгэрхангай сумын “Ар булгийн ундарга” ХХК-ний хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

2. Өндөршил сумын “Чебу” ХХК-ний хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаагаар сунгасугай.

3. Гарсан шийдвэрийг холбогдох газарт хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100497